Нууцын зэрэглэл: Б

Улсын бүртгэлийн
дугаар: 9104399

Аравтын бүрэн
ангиллын код:

Төсөл хэрэгжүүлэх
гэрээний дугаар:
ШУСС-2019/17

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

“Тухайн уламжлалт дифференциал тэгшитгэлийн алгебр ба аналитик судалгаа”

Суурь судалгааны төслийн тайлан

(2019-2022)

Төслийн удирдагч: А.Галтбаяр (Ph.D.)

Санхүүжүүлэгч байгууллага: Шинжлэх Ухаан Технологийн Сан

Захиалагч байгууллага: Боловсрол Шинжлэх Ухааны Яам

Тайлан өмчлөгч: МУИС, ХШУИС, Их сургуулийн гудамж 3, Улаанбаатар, 21046, Утас 9903-0920, и-мейл хаяг: galtbayar@seas.num.edu.mn

Улаанбаатар хот

2022 он

“Тухайн уламжлалт дифференциал тэгшитгэлийн алгебр ба аналитик судалгаа” (2019-2022)

Гарчиг

1. Төслийн ерөнхий мэдээлэл

- Төслийн нэр: Тухайн уламжлалт дифференциал тэгшитгэлийн алгебр ба аналитик судалгаа,
- Төсөл хэрэгжсэн хугацаа: 2019-2022,
- Төслийн нийт санхүүжилт: 35 сая төгрөг,
- Төслийн багийн бүрэлдхүүн

  Удирдагч: А. Галтбаяр (МУИС, ХШУИС, профессор)

  Гишүүд:

  1. З. Ууганбаяр (МУИС, ШУС, дэд профессор, Ph.D, үндсэн гүйцэтгэгч)
  2. Д. Даянцолмон (МУИС, ШУС, дэд профессор, Ph.D, үндсэн гүйцэтгэгч)
  3. Д. Хонгорзул (МУИС, ХШУИС, дэд профессор, Ph.D, үндсэн гүйцэтгэгч)
  4. Э. Ганхөлөг (МУИС, ХШУИС, магистр)
  5. Э. Тэлмэн (МУИС, ХШУИС, магистр)

2. Судалгааны зорилго, түүний биелэлт

“Тухайн уламжлалт дифференциал тэгшитгэлийн алгебр ба аналитик судалгаа” сэдэвт суурь судалгааны төсөл нь математик физикийн үндсэн тэгшитгэлүүдийн шийдийн чанарын талаарх судалгааны төсөл бөгөөд

1. Квант механикийн үндсэн тэгшитгэлүүдийн нэг болох Шредингерийн тэгшитгэлийн шийдийн талаар
2. Хугацаагаар авсан уламжлал нь бутархай зэрэгтэй байх дулааны болон долгионы тэгшитгэлүүдийн шийдийн талаар

гэсэн 2 үндсэн чиглэлтэй болно. Төслийн хугацаанд чиглэл тус бүрээр бие даасан судалгааны семинаруудыг тогтмол явуулж, ахисан түвшний оюутнуудыг уг судалгаанд хамруулж байсан. Мөн судалгааны явцын үр дүнгүүдийг тухай бүрт нь эрдэм шинжилгээний хурлуудад илтгэж байсан бөгөөд тэдгээрийг нэгтгэн олон улсын өндөр зэрэглэлийн сэтгүүлүүдэд хэвлүүлсэн юм. Төслийн явцад математик физикийн загваруудыг судлах, түүнийг бодит амьдралаас үүдэн гарсан бодлогуудыг шийдэхэд хэрэглэх, оюутнуудын хичээлээр олж авсан мэдлэгээ батжуулах, хэрэглэж сурах үйл явцыг дэмжих үүднээс “Хэрэглээний математик” эрдэм шинжилгээний хурлууд, үйлдвэрлэлтэй хамтарсан судалгааны семинарыг зохион байгуулахад төслийн багийн гишүүд гар бие оролцсоноос гадна санхүүгийн дэмжлэг үзүүлж байлаа.

Эхний чиглэлийн судалгааны чиглэл болох Шредингерийн тэгшитгэлийн шийд, харгалзах операторын спектр ба сарнилын бодлогын талаарх судалгааг төсөл эхлэхэд төсөөлж байснаас илүү өргөтгөсөн бөгөөд тухайлбал хугацаанаас хамаарсан потенциал бүхий Шредингерийн тэгшитгэлийн шийдийн хувьд Адиабатик теорем биелэхгүй байх жишээг гаргасан юм.

Төслийн тайланг үйл ажиллагаа болон үр дүнг цаг хугацааны дараалаар нэгтгэж гарган, эцэст нь гол үр дүнгүүдийг дурьдсан болно. Мөн санхүүгийн тайланг нэмж оруулсан болно. Хавсралтад хэвлүүлсэн өгүүллүүд эх хувь, хурлын хөтөлбөрүүд болон санхүүгийн баримтуудыг хавсаргалаа.

Бүлэг 3

Судалгааны үр дүн

3.1 Шредингерийн операторын спектр, сарнилын бодлогууд, шийдийн чанар

3.1.1 Регуляр потенциал бүхий Шредингерийн операторoор цэгэн харилцан үйлчлэлтэйг дөхөх

Шредингерийн операторын сарнилын бодлогын гол асуудал түүний долгионы операторын оршин байх, гүйцэт байх эсэх тухай байдаг. Олон биеийн бодлогын хувьд энэ асуудлыг 1990-ээд онд Волкер Энс нарын эрдэмтэд шийдсэн юм. Үүнээс цаашлаад долгионы операторын чанаруудын талаарх (тухайлбал L^p-зааглагдах эсэх) судалгааг хэмжээс болон потенциалын төрөл, чанараас хамааруулан олон судлаачид хийж байна [17], [2], [4]. Бид дараах ажлаараа цэгэн харилцан үйлчлэл бүхий Шредингерийн операторын долгионы операторыг энгийн Шредингерийн операторын долгионы операторын хязгаар хэлбэрээр илэрхийлж болохыг $\mathbb{R}^3$ дээрх N биеийн бодлогын хувьд баталж харуулсан болно. Үүнтэй холбоотой ажлыг [1] ажилд авч үзсэн байдаг.

$\mathbb{R}^3$ дээр $Y = \{y_1, \ldots, y_N\}$ гэсэн ялгаатай N цэг авья. $\mathcal{H} = L^2(\mathbb{R}^3)$ огторгуйд цэгэн харилцан үйлчлэл бүхий Шредингерийн оператор $H_{\alpha,Y}$ нь y_j цэг бүр дээр $\alpha_j \in \mathbb{R}$, $j = 1, \ldots, N$ параметраар өгөгдөх захын нөхцөлөөр тодорхойлогдсон бөгөөд резольвент адилтгалын тусламжтайгаар бичвэл

$$(H_{\alpha,Y} - z^2)^{-1} = (H_0 - z^2)^{-1} + \sum_{j,\ell=1}^{N} (\Gamma_{\alpha,Y}(z)^{-1})_{j\ell}\, \mathcal{G}_z^{y_j} \otimes \overline{\mathcal{G}_z^{y_\ell}}, \tag{3.1}$$

байдаг гэе. Энд $H_0 = -\Delta$ нь чөлөөт Шредингерийн оператор, $z \in \mathbb{C}^+ = \{z \in \mathbb{C} | \Im z > 0\}$, $\alpha = (\alpha_1, \ldots, \alpha_N) \in \mathbb{R}^N$. Мөн энд $\Gamma_{\alpha,Y}(z)$ нь

$$\Gamma_{\alpha,Y}(z) \ := \ \Big(\Big(\alpha_j - \frac{iz}{4\pi}\Big)\delta_{j\ell} - \mathcal{G}_z(y_j - y_\ell)\hat{\delta}_{j\ell}\Big)_{j,\ell=1,\ldots,N}, \tag{3.2}$$

хэлбэртэй, элементүүд $z \in \mathbb{C}$-ээс хамаарсан голоморф функцүүд байх $N \times N$ хэмжээтэй симметр матриц юм. Энд $\delta_{j\ell}$ нь Кронекерийн символ, мөн

$$\mathcal{G}_z(x) = \frac{e^{iz|x|}}{4\pi|x|} \text{ ба } \mathcal{G}_z^y(x) = \frac{e^{iz|x-y|}}{4\pi|x-y|} \tag{3.3}$$

$(H_0 - z^2)^{-1}$ операторын цөм юм. Тэгвэл долгионы оператор $W^{\pm}_{\alpha,Y}$ defined by the limits

$$W^{\pm}_{\alpha,Y} u = \lim_{t \to \pm\infty} e^{itH_{\alpha,Y}} e^{-itH_0} u, \quad u \in \mathcal{H} \tag{3.4}$$

нь орших ба гүйцэт буюу $\mathrm{Image}\, W^{\pm}_{\alpha,Y} = \mathcal{H}_{ac}$ байна. Энд $\mathcal{H}_{ac}$ нь $\mathcal{H}$-д харгалзах $H_{\alpha,Y}$ дэд огторгуй.

Регуляр потенциал бүхий Шредингерийн операторыг

$$\overline{H}_Y(\varepsilon) = -\Delta + \sum_{i=1}^{N} \frac{\lambda_i(\varepsilon)}{\varepsilon^2} V_i \left(\frac{x - y_i}{\varepsilon}\right), \tag{3.5}$$

гэж тодорхойльё.

Тэгвэл $\varepsilon \to 0$ үед дээрх операторуудад харгалзах долгионы операторууд хэрхэн холбогдохыг дараах үр дүнгээр баталж үзүүлсэн болно.

Теорем 1. *Бид потенциал функцүүд дараах нөхцлүүдийг хангадаг гэе:*

(1) $V_1, \ldots, V_N$ *нь бодит функцүүд бөгөөд* $p < 3/2$, $q > 3$ *хувьд*

$$\langle x \rangle^2 V_j \in (L^p \cap L^q)(\mathbb{R}^3), \quad j = 1, \ldots, N \tag{3.6}$$

байг.

(2) *$\lambda_1(\varepsilon), \dots, \lambda_N(\varepsilon)$ нь $\varepsilon > 0$-ээс хамаарсан, бодит C^2-ангийн функц ба*

$$\lambda_j(0) = 1, \quad \lambda_j'(0) \neq 0, \quad \forall j = 1, \dots, N.$$

байг.

(3) *$H_j = -\Delta + V_j$, $j = 1, \dots, N$ операторын 0 энерги нь резонанстай байг.*

Тэгвэл дараах өгүүлбэрүүд үнэн байна:

(a) *$\overline{H}_Y(\varepsilon)$ нь $\varepsilon \to 0$ үед Y дээр байрлах, $\alpha = (\alpha_1, \dots, \alpha_N)$ параметрээс хамаардаг цэгэн харилцан үйлчлэл бүхий $H_{\alpha,Y}$ Шредингерийн оператор руу резольвентын хүчтэй дөхөлтийн утгаар буюу*

$$\lim_{\varepsilon \to 0} (\overline{H}_Y(\varepsilon) - z^2)^{-1} u = (H_{\alpha,Y} - z^2)^{-1} u, \quad \forall u \in \mathcal{H}, \tag{3.7}$$

байна.

(b) *Wave operators for the pair $(\overline{H}_Y(\varepsilon), H_0)$ хосын хувьд тодорхойлогдсон $W^{\pm}_{Y,\varepsilon}$ долгионы оператор*

$$W^{\pm}_{Y,\varepsilon} u = \lim_{t \to \pm\infty} e^{it\overline{H}_Y(\varepsilon)} e^{-itH_0} u, \quad u \in \mathcal{H} \tag{3.8}$$

нь хүчтэй дөхөлтийн утгаар орших ба гүйцэт байна. $W^{\pm}_{Y,\varepsilon}$ оператор нь

$$\lim_{\varepsilon \to 0} \| W^{\pm}_{Y,\varepsilon} u - W^{\pm}_{\alpha,Y} u \|_{\mathcal{H}} = 0, \quad u \in \mathcal{H}. \tag{3.9}$$

тэнцэтгэлийг хангана.

3.1.2 Адиабатик теорем биелэхгүй байх нэгэн тохиолдлын талаар

Хугацаанаас хамаарсан потенциал бүхий Шредингерийн тэгшитгэлийн шийд нь урт хугацаанд ямар чанартай байх нь сонирхолтой бодлогуудын нэг билээ. Хугацаанаас хамаардаг потенциал нь үетэй функц байх эсвэл хангалттай хугацааны дараа нөлөө нь багасдаг зэрэг олон тохиолдлуудыг авч үздэг юм . Үүн дотроос анхны нөхцлийн функцийг Гауссын тархалттай төстэй, экспоненциал буурдаг хувийн функцээр сонгосон тохиолдолд Шредингерийн тэгшитгэлийн шийд нь хангалттай урт хугацаанд анхны нөхцлийн функцийн чанараа хадгалдаг гэсэн үр дүнг Адиабатик дөхөлтийн теоремоор Т.Като [12] баталсан байдаг. Уг теоремыг эхлээд томьёольё.

$\mathcal{H}$ нь Гильберт огторгуй ба $\{H(t)\colon -a < t < a\}$ нь $\mathcal{H}$-д тодорхойлогдсон өөртөө хосмог операторын бүл байг. $0 < \varepsilon \ll 1$ бага параметрээс хамаарсан

$$i\varepsilon\partial_t u(t) = H(t)u(t) \tag{3.10}$$

Шредингерийн тэгшитгэлийн шийд нь цор ганц унитар групп $U_\varepsilon(t,s)$-г тодорхойлдог гэе. $\lambda(t)$ ба $\varphi(t)$ нь харгалзан $H(t)$ операторын тусгаарлагдсан хувийн утга, нормчлогдсан хувийн функц буюу

$$H(t)\varphi(t) = \lambda(t)\varphi(t), \quad \|\varphi(t)\|^2 = 1, \quad -a < t < a$$

байг. Борн-Фок ба Kato [3], [12] нарын үр дүн болох Адиабатик дөхөлтийн теорем ёсоор Шредингерийн тэгшитгэлийн

$$i\varepsilon\partial_t u_\varepsilon(t) = H(t)u_\varepsilon(t), \quad u_\varepsilon(0) = \varphi(0), \tag{3.11}$$

Кошийн бодлогын шийд $u_\varepsilon(t) = U_\varepsilon(t,0)\varphi(0)$ нь $0 < \varepsilon \to 0$ үед хувийн функцийн ε орчинд $-\delta < t < \delta$, $0 < \delta < a$ хугацааны туршид орших буюу өөрөөр хэлбэл

$$\|u_\varepsilon(t) - e^{-i\varepsilon^{-1}\int_0^t \lambda(s)ds}\varphi(t)\| \le C_\delta \varepsilon \tag{3.12}$$

байна. Энд $\|\cdot\|$ нь $L^2(\mathbb{R})$ огторгуйн норм.

Одоо $\lambda(t)$ хувийн утга нь $t \le -L$ үед $H(t)$-ийн тусгаарлагдсан хувийн утгаас тасралтгүй спектрийн рүү шилжээд, хэсэг хугацаанд буюу $-L \le t \le L$ үед тасралтгүй спектр дотор(embedded eigenvalue) байж байгаад, дахин $t > L$ үед тусгаарлагдсан хувийн утга рүү шилжих тохиолдолд адиабатик теорем хүчинтэй болохыг S.Teufel [15] баталсан байдаг. Тэгвэл өмнөх тохиолдолд $-L \le t \le L$ хугацааны туршид $H(t)$-ийн хувийн утга алга болж, зөвхөн тасралтгүй спектр үлддэг бол шийд ямар байх талаар ямар нэг үр дүн байхгүй юм. Бид энэ тохиолдлыг дараах бодогддог жишээгээр авч үзэхэд Адиабатик теорем биелдэггүй болох нь харагдсан юм.

$$i\varepsilon\partial_t u_\varepsilon = -\frac{1}{2}\partial_x^2 u_\varepsilon + V(t,x)u_\varepsilon, \quad u_\varepsilon(-L-1,x) = \varphi_0(x), \tag{3.13}$$

бодлогын хувьд потенциал нь $t < -L$, $t > L$ үед гармоник осциллятор ба $-L \leq t \leq L$ үед $V(t,x) = 0$ буюу

$$V(t,x) = \begin{cases} (t+L)^2x^2/2, & t < -L, \\ 0, & -L \leq t \leq L, \\ (t-L)^2x^2/2, & L > t, \end{cases} \tag{3.14}$$

гэе. Анхны нөхцлийн функц $\varphi_0(x) = (\pi^{\frac{1}{4}})^{-1}e^{-x^2/2}$ нь $H(-L-1) = -(1/2)\Delta + (1/2)x^2$ операторын нормчлогдсон хувийн функц юм. Энэ x^2t^2 потенциалтай Шредингерийн тэгшитгэлийн шийдийн талаар [16] ажилдаа авч үзсэн байдаг. Формал үр дүнг теорем хэлбэрээр бичье.

Теорем 2. (1)

$$m_\varepsilon(1/\varepsilon) = \frac{\pi^{-1/4}}{(\sqrt{2}e^{i/\varepsilon} + i)^{1/2}} + O(\varepsilon)\,. \tag{3.15}$$

$$l_\varepsilon^*(t) = \frac{-i\big(\kappa_\varepsilon J_{-\frac{3}{4}}(\frac{1}{8\varepsilon}) + J_{\frac{3}{4}}(\frac{1}{8\varepsilon})\big)}{-J_{-\frac{1}{4}}(\frac{1}{8\varepsilon}) + \kappa_\varepsilon J_{\frac{1}{4}}(\frac{1}{8\varepsilon})}, \tag{3.16}$$

байг. (3.13) бодлогын шийд $u_\varepsilon(\varepsilon s, x) = v_\varepsilon(s,x)$ *бол* $\varepsilon \to 0$ *үед*

$$\|v_\varepsilon(1/\varepsilon, x) - m_\varepsilon(1/\varepsilon)e^{-l_\varepsilon^*(1/\varepsilon)x^2/2}\| \leq C\varepsilon. \tag{3.17}$$

Энд $O(\varepsilon)$ *эрэмбийн гишүүн нь*

$$|m_\varepsilon(1/\varepsilon)|^4 = \pi^{-1}\big(3 + 2\sqrt{2}\sin(1/\varepsilon)\big) = \pi^{-1}\Re l_\varepsilon^*(1/\varepsilon) \tag{3.18}$$

байна.
(2) $\varphi_0(x) = \pi^{-\frac{1}{4}}e^{-x^2/2}$ *анхны нөхцлийн функцийн* $1/\varepsilon$ *хугацаанд үлдэх магадлал нь* $1/\sqrt{2} + O(\varepsilon)$ *байна.*

3.1.3 Квант орны Паули-Фиерцийн загвар

Шредингерийн тэгшитгэл нь атомын цөм ба электроны харилцан үйлчлэлийг тайлбарладаг бөгөөд үүн дээр харьцангуй сул харилцан үйлчлэл болох орны үйлчлэлийг тооцсон загварыг бодох нь математик физикийн бас нэгэн сонирхолтой бодлого хэдий ч нэлээд комплекс, ярвигтай бодлого гэж тооцогддог[10], [11], [7], [6].

Бид энэ ажилдаа чөлөөт бөөмд (электрон) цөөн тооны фотоны үйлчлэхэд энергийн шилжилт хэрхэн явагдаж байгааг харуулсан маш энгийн загварыг авч үзэж байгаа юм. Фотоны тоон дээр зааглал тавьсанаар бодлогын аналитик шийдийг олж, улмаар харгалзах операторын спектрын талаар маш тодорхой үр дүн гаргаж авсан юм. Энэ загвартай төстэй асуудлыг [13], [8], [9] ажлуудад хөндөж байсан бөгөөд бидний энэ ажлын анхны сэдлийг T.Miyao [14] өгсөн болно. Эхлээд загвараа товч танилцуулж, дараа гаргаж авсан үр дүнгээ теорем хэлбэрээр бичье. Бид

$$\mathcal{H} := L^2(\mathbb{R}^3_x) \otimes \mathcal{F}.$$

гэсэн Гильберт огторгуй авч үзэх бөгөөд $\mathcal{F}$ нь

$$\mathcal{F} = \oplus_{n=0}^{\infty} \mathcal{F}^{(n)} =: \oplus_{n=0}^{\infty} (\otimes_s^n \mathcal{S})$$

байх Фок огторгуй ба $\mathcal{S} = L^2(\mathbb{R}^3) \oplus L^2(\mathbb{R}^3)$ байг. $\otimes_s^n \mathcal{S}$-ээр $\mathcal{S}$ огторгуйн n-дахин авсан симметр тензор үржвэрийг тэмдэглэв.

$v = (v(k,1), v(k,2)) \in L^2(\mathbb{R}^3) \oplus L^2(\mathbb{R}^3)$ векторын хувьд $a(v)$, $a^*(v)$ гэсэн "annihilation"ба "creation"операторуудыг

$$a^\sharp(v) = \sum_{\lambda=1}^{2} \int a^\sharp(k,\lambda) v(k,\lambda) dk$$

байдлаар тодорхойлно. Энд a эсвэл a^*-г $a^\sharp$ гэж тэмдэглэсэн ба $a^\sharp(k,\lambda)$ нь түүний оператор цөм нь байг.

Чөлөөт фотоны энерги

$$H_f = \sum_{\lambda=1}^{2} \int \omega(k) a^*(k,\lambda) a(k,\lambda) dk,$$

гэж өгөгдөх ба $\omega(k) = |k|$ болно.

Квантчилагдсан орныг $A_g(x) = (A_{g1}(x), A_{g2}(x), A_{g3}(x))$, $x \in \mathbb{R}^3$ гэж тэмдэглэвэл

$$A_{gj}(x) = \frac{1}{\sqrt{2}} \sum_{\lambda=1}^{2} \int e_j(k,\lambda) \left[g(k) e^{-ik\cdot x} a^*(k,\lambda) + \overline{g(k)} e^{ik\cdot x} a(k,\lambda) \right] dk$$

тодорхойлогддог байг. Энд $e(k,\lambda) = (e_1(k,\lambda), e_2(k,\lambda), e_3(k,\lambda)$ нь

$$k \cdot e(k,\lambda) = 0, \quad e(k,\lambda) \cdot e(k,\mu) = \delta_{\lambda\mu}, \qquad \lambda, \mu = 1, 2$$

нөхцлүүдийг хангадаг поляризацийн вектор гэж нэрлэгдэх векторууд болог. Тэгвэл бид Паули-Фиерцийн операторыг

$$H = \frac{1}{2}(-i\nabla_x \otimes 1 - eA_g(x))^2 + 1 \otimes H_f,$$

гэж тодорхойлно. Энд e орны харилцан үйлчлэлийн констант.

Одоо тотал моментын огторгуй руу буулгавал Паули-Фиерцийн оператор хялбар хэлбэрт орох бөгөөд $\mathcal{F}$ огторгуйд

$$\bar{H}(p) \;\; = \;\; \frac{1}{2}(p - P_f - eA_g(0))^2 + H_f$$

операторыг авч үзэхэд хангалттай. Фотоны тоог 2-оор хязгаарлан, харгалзах Паули-Фиерцийн операторыг $H(p)$ гэж тэмдэглэе. Тэгвэл дараах теорем биелнэ.

Теорем 3. *(1) Дурын $p \in \mathbb{R}^3$ хувьд*

$$z_0(|p|) = \min_{k \in \mathbb{R}^3} \left\{ \frac{1}{2}(p-k)^2 + |k| + \gamma_0 \right\} = \begin{cases} \frac{1}{2}p^2 + \gamma_0, & \text{хэрэв } |p| \leq 1, \\ |p| - 1/2 + \gamma_0, & \text{хэрэв } |p| > 1. \end{cases}$$

нь $(|p|, z)$ хавтгайн муруй байг. $\gamma_0 = \frac{\pi}{1+\sigma}e^2 R^{2+2\sigma}$ ба $R > 0$ тоо нь ультраягаан үйлчлэлийн радиус. Тэгвэл $H(p)$ операторын спектр нь

$$\operatorname{spec} H(p) = \begin{cases} z^*(p) \cup [z_0(|p|), +\infty), & 0 \leq |p| < \rho \quad \text{үед }, \\ [z_0(|p|), +\infty), & \text{бусад тохиолдолд} \end{cases}$$

байна. Энд $z^*(p)$ нь $H(p)$-ын хувийн утга болно.
(2) $E_\sigma(p) = \inf H(p)$ гэвэл эффектив масс гэж нэрлэгдэх тоог

$$\frac{1}{m_{eff}} = \lim_{\sigma \to 0} \frac{\partial^2 E_\sigma(p)}{\partial |p|^2}\Big|_{p=0}.$$

гэж тодорхойльё. Паули-Фиерцийн $H(p)$ операторын хувьд

$$\frac{1}{m_{eff}} = \frac{1 - \frac{8}{3}\pi e^2 \ln(R/2+1)}{1 + \frac{8}{3}\pi e^2 \ln(R/2+1)}$$

томьёо хүчинтэй байна.

3.2 Хугацаагаар бутархай эрэмбийн уламжлалтай, хувьсах коэффициенттэй, конвекц-диффузийн тэгшитгэл, инвариант шийдүүдийн тухай

Оливер Хэвисайдын 1880-д оны үед зохиогдсон дамжуулах шугамын цахилгаан соронзон долгионы шинж чанарыг илэрхийлэх телеграфийн тэгшитгэл нь өндөр давтамжтай цахилгаан хэлхээ зэрэг цахилгааны салбарт чухал үүрэгтэй байдаг. Олон төрлийн сонгодог тухайн уламжлалт дифференциал тэгшитгэлүүдийн хугацаагаар авсан уламжлалыг бутархай эрэмбийн уламжлал болгон сольсон хувилбарууд нь тухайн физик үзэгдлүүдийг илүү сайн тайлбарладаг болох нь сүүлийн жилүүдэд олон судалгаагаар харагдаж байна. Бид энэ ажлаар

$$\begin{cases} \frac{\partial^\alpha u}{\partial t^\alpha} = v_x, \\ \frac{\partial^\alpha v}{\partial t^\alpha} = f(x)u_x + g(x)u, \end{cases} \tag{3.19}$$

тэгшитгэлийг судална. Энд бутархай эрэмбийн уламжлал нь Риман-Луивиллын тодорхойлолтоор

$$\frac{\partial^\alpha u(x,t)}{\partial t^\alpha} := \begin{cases} \frac{\partial^n u}{\partial t^n}, & \text{хэрэв } \alpha \in \mathbb{N}, \\ \frac{1}{\Gamma(n-\alpha)} \frac{\partial^n}{\partial t^n} \int_0^t \frac{u(x,s)}{(t-s)^{\alpha-n+1}} ds, & \text{хэрэв } \alpha \in (n-1, n) \text{ ба } n \in \mathbb{N}. \end{cases} \tag{3.20}$$

өгөгдсөн бөгөөд $f(x)$, $g(x)$ нь хангалттай удаа дифференциалчлагддаг функцүүд байна.
Уг системийн өмнө судлагдсан байдал:

- (3.19) системийн $\alpha = 1$ болон $g(x) = 0$ тохиолдлыг Блюман, Күмей нар 1987 онд [34] ажилд Ли-гийн бүлгэн ангиллыг хийж, зарим инвариант шийдүүдийг олсон.

- 2015 онд Хуан, Шен нар [37] ажилд өмнөх зүйлд дурьдагдсан ажлын хугацаагаар бутархай эрэмбийн тохиолдлын буюу (3.19) системийн $\alpha > 0$, $g(x) = 0$ тохиолдлыг судалж Ли-гийн симметрүүдийг олж харуулсан.

- 2019 онд бид [38] ажилд $\alpha > 0$, $g(x) = 0$ тохиолдлыг судалж, Ли-гийн симметр бүлгэн ангиллыг хийж, инвариант шийдүүдийг тусгай функцээр илэрхийлж олсон. Уг ажлаар судалсан систем маань хувьсах коэффициент $f(x)$-ээс хамааран хувьсагч нь ялгагдах, хувьсагч нь ялгагдахгүй болон хувьсагч нь ялгагдаж ч болдог, ялгагдахгүй ч байж болдог 3 төрөлд ангилагдаж байгааг олж тогтоосон.

Энэ ажилд бид өмнө судалсан [38] ажлаа өргөтгөн $g(x) \neq 0$ тохиолдлыг судална. Товчхондоо, бид $f(x)$ болон $g(x)$ хувьсах функцүүдээс хамааруулан (3.19) системийн Ли-гийн бүлгэн ангиллыг хийж, ангилал болгон дахь Ли-гийн симметрүүдээс тогтох Ли алгебрийн оптимал алгебрийг олж, оптимал алгебрийн хувиргалт бүрд харгалзах инвариант шийдүүдийг Миттаг-Леффлер, өргөтгөсөн Райт, Фокс Эйч тусгай функцүүдээр илэрхийлж харуулна.

3.2.1 Хугацаагаар бутархай эрэмбийн уламжлалтай конвекц-диффузийн тухайн уламжлалт дифференциал тэгшитгэлийн Ли-гийн симметр анализ

(3.19) системийн Ли-гийн симметрүүдийг олохын тулд бид эхлээд

$$\begin{cases} \tilde{X}\left(u_{t^\alpha} - v_x\right)|_{(3.19)} = 0, \\ \tilde{X}(v_{t^\alpha} - f(x)u_x - g(x)u)|_{(3.19)} = 0. \end{cases}$$

гэсэн тодорхойлогч системийн шийдийг олох ёстой. Энд өргөтгөсөн инфинитезимал үүсгүүр нь

$$\tilde{X} = \xi\frac{\partial}{\partial x} + \tau\frac{\partial}{\partial t} + \mu\frac{\partial}{\partial u} + \phi\frac{\partial}{\partial v} + \mu^{(\alpha)}\frac{\partial}{\partial u_{t^\alpha}} + \mu^{(1)}\frac{\partial}{\partial u_x} + \cdots + \phi^{(\alpha)}\frac{\partial}{\partial v_{t^\alpha}} + \phi^{(1)}\frac{\partial}{\partial v_x} + \cdots, \tag{3.21}$$

гэж тодорхойлогдоно. Энд τ, ξ, μ болон ϕ нь инфинитезималууд, $\mu^{(\alpha)}$, $\mu^{(n)}$, $\phi^{(\alpha)}$ болон $\phi^{(n)}$ $(n = 1, 2, \ldots)$ нь [40]-д өгөгдсөн өргөтгөсөн инфинитезималууд байна. Тодорхойлогч системийг задалж бичвэл

$$\begin{cases} \left(\mu^{(\alpha)} - \phi^{(1)}\right)\Big|_{(3.19)} = 0, \\ \left(\phi^{(\alpha)} - f_x\xi u_x - f\mu^{(1)} - g_x u\xi - g\mu\right)\Big|_{(3.19)} = 0. \end{cases} \tag{3.22}$$

болно. Дээрх системийн хоорондоо шугаман хамааралгүй $D_t^{\alpha-n}u$, $D_t^{\alpha-n}v$, $D_t^{\alpha-n}u_x$, $D_t^{\alpha-n}v_x$, v_x, u_x, v_t, u_xv_t, v_xv_t, u_xv_x, v_x^2 гэсэн тухайн уламжлалуудын болон тогтмол тоо буюу 1-ийн өмнөх коэффициентүүдийг бүгдийг нь тус тус тэгтэй тэнцүүлбэл (3.22) систем нь

$$\binom{\alpha}{n}\frac{\partial^n \mu_u}{\partial t^n} - \binom{\alpha}{n+1} D_t^{n+1}(\tau) = 0, \qquad n = 1, 2, \ldots, \tag{3.23}$$

$$\frac{\partial^n \mu_v}{\partial t^n} = 0, \qquad n = 1, 2, \ldots, \tag{3.24}$$

$$D_t^n(\xi) = 0, \qquad n = 1, 2, \ldots, \tag{3.25}$$

$$\mu_u - \alpha D_t(\tau) - \phi_v + \xi_x = 0, \tag{3.26}$$

$$f\mu_v - \phi_u = 0, \tag{3.27}$$

$$\frac{\partial^\alpha \mu}{\partial t^\alpha} - u\frac{\partial^\alpha \mu_u}{\partial t^\alpha} - v\frac{\partial^\alpha \mu_v}{\partial t^\alpha} + gu\mu_v - \phi_x = 0, \tag{3.28}$$

$$\frac{\partial^n \phi_u}{\partial t^n} = 0, \qquad n = 1, 2, \ldots, \tag{3.29}$$

$$\binom{\alpha}{n}\frac{\partial^n \phi_v}{\partial t^n} - \binom{\alpha}{n+1} D_t^{n+1}(\tau) = 0, \qquad n = 1, 2, \ldots, \tag{3.30}$$

$$f\phi_v - \alpha f D_t(\tau) - f_x\xi - f\mu_u + f\xi_x = 0, \tag{3.31}$$

$$\frac{\partial^\alpha \phi}{\partial t^\alpha} - v\frac{\partial^\alpha \phi_v}{\partial t^\alpha} - u\frac{\partial^\alpha \phi_u}{\partial t^\alpha} + gu\phi_v - \alpha gu D_t(\tau)$$
$$-g_xu\xi - g\mu - f\mu_x = 0, \tag{3.32}$$

$$\tau_x = \tau_u = \tau_v = 0, \tag{3.33}$$

$$\xi_u = \xi_v = 0. \tag{3.34}$$

болно. Энд, бид μ, ϕ инфинитезималуудыг u болон v хувьсагчдаар шугаман гэж үзнэ. (3.23)-(3.34) тэгшитгэлүүдэд анализ хийснээр бид (3.19) системийг дараах 2 дүгнэлтийг хийж болно.

1. (3.19) систем нь дурын хувьд дараах симметрүүдтэй байна

$$X_0 = c_1(x,t)\frac{\partial}{\partial u} + c_2(x,t)\frac{\partial}{\partial v} \quad \text{болон} \quad X_1 = u\frac{\partial}{\partial u} + v\frac{\partial}{\partial v}.$$

   Энд, $c_1(x,t)$, $c_2(x,t)$ нь (3.19) системийн дурын шийд байна. Мэдээж X_0 симметр нь анхны системийн шугаман чанарыг илэрхийлж байна.

2. f, g коэффициент функцүүдийн дараах тохиолдлуудад (3.19) систем нь нэмэлт Ли-гийн симметртэй байна. (3.23)-(3.34) тэгшитгэлүүдэд анализ хийснээр f, g коэффициент функцүүд нь $f_x - 2g$ илэрхийлэл 0-тэй тэнцэх эсэхээс хамааран (3.19) дараах хоёр тохиолдолд хуваагдана.

Тохиолдол 1

$f_x - 2g \neq 0$ гэж үзье. Энэ тохиолдолд, (3.23)-(3.34) тэгшитгэлүүдэд анализ хийсний дүнд дараах хоёр дэд тохиолдлууд гарна.

Тохиолдол 1.1

$\left(\sqrt{f(x)}\right)' - \frac{g(x)}{\sqrt{f(x)}} \neq 0$ тохиолдол авч үзье. f болон g функцүүд нь

$$g(x) = \frac{\lambda_2 f^{\frac{1}{2}}}{\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}} dx} + \frac{f_x}{2},\ \lambda_1, \lambda_2 \in \mathbb{R},\ \lambda_2 \neq 0$$

хангадаг байна. Тэгвэл дурын $f(x)$ болон $g(x) = \frac{\lambda_2 f^{\frac{1}{2}}}{\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}} dx} + \frac{f_x}{2}$ (энд $\lambda_1, \lambda_2 \in \mathbb{R}$, $\lambda_2 \neq 0$) функцийн хувьд (3.19) систем нь X_0, X_1-ээс гадна

$$X_2 = f^{\frac{1}{2}} \left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}} dx\right) \frac{\partial}{\partial x} + \frac{t}{\alpha} \frac{\partial}{\partial t} - \frac{f_x}{2 f^{\frac{1}{2}}} \left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}} dx\right) u \frac{\partial}{\partial u}.$$

нэмэлт симметрүүдтэй байна.

Тохиолдол 1.2

$\left(\sqrt{f(x)}\right)' - \frac{g(x)}{\sqrt{f(x)}} \neq 0$ тохиолдол авч үзье. Тэгвэл дурын $f(x)$ функц болон

$$g(x) = \lambda_2 f^{\frac{1}{2}} + \frac{f_x}{2},\ \lambda_2 \in \mathbb{R},\ \lambda_2 \neq 0$$

функцийн хувьд (3.19) систем дараах нэмэлт симметрүүдтэй байна

$$X_3 = f^{\frac{1}{2}} \frac{\partial}{\partial x} - \frac{f_x}{2 f^{\frac{1}{2}}} u \frac{\partial}{\partial u}.$$

Тохиолдол 2

$f_x - 2g = 0$ тохиолдлыг авч үзье. Энэ тохиолдолд (3.19) систем дараах 3 нэмэлт симметрүүдтэй байна

$$\begin{aligned} X_4 &= f^{\frac{1}{2}} \int f^{-\frac{1}{2}} dx \frac{\partial}{\partial x} + \frac{t}{\alpha}\frac{\partial}{\partial t} - \frac{f_x}{2f^{\frac{1}{2}}} \int f^{-\frac{1}{2}} dx u \frac{\partial}{\partial u}, \\ X_5 &= f^{\frac{1}{2}} \frac{\partial}{\partial x} - \frac{f_x}{2f^{\frac{1}{2}}} u \frac{\partial}{\partial u}, \\ X_6 &= f^{-\frac{1}{2}} v \frac{\partial}{\partial u} + f^{\frac{1}{2}} u \frac{\partial}{\partial v}. \end{aligned}$$

Бид энэ хэсгийн гол үр дүнгээ дараах байдлаар томъёолж болно.

Теорем 4. *(3.19) тэгшитгэлийн системээр өгөгдсөн хувьсах коэффициенттэй, бутархай эрэмбийн дифференциал тэгшитгэлийн систем авч үзье. Тэгвэл,*

i) дараах гурван тохиолдлоос ялгаатай дурын $f(x)$ болон $g(x)$ функцүүдийн хувьд (3.19) систем нь

$$X_0 = c_1(x,t)\frac{\partial}{\partial u} + c_2(x,t)\frac{\partial}{\partial v}, \quad and \ X_1 = u\frac{\partial}{\partial u} + v\frac{\partial}{\partial v},$$

гэсэн хоёр симметртэй байна. Энд, $c_1(x,t)$ болон $c_1(x,t)$ нь (3.19) системийн дурын шийд байна.

ii) дурын $f(x)$ болон $g(x) = \frac{\lambda_2 f^{\frac{1}{2}}}{\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}} dx} + \frac{f_x}{2}$ (энд $\lambda_1, \lambda_2 \in \mathbb{R}, \ \lambda_2 \neq 0$) функцүүдийн хувьд (3.19) систем нь X_0, X_1-с гадна дараах симметрүүдтэй байна

$$X_2 = f^{\frac{1}{2}} \left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}} dx\right) \frac{\partial}{\partial x} + \frac{t}{\alpha}\frac{\partial}{\partial t} - \frac{f_x}{2f^{\frac{1}{2}}} \left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}} dx\right) u \frac{\partial}{\partial u}.$$

iii) дурын $f(x)$ болон $g(x) = \lambda_2 f^{\frac{1}{2}} + \frac{f_x}{2}$ (энд $\lambda_2 \in \mathbb{R}, \ \lambda_2 \neq 0$) функцүүдийн хувьд (3.19) систем нь X_0, X_1-с гадна дараах симметрүүдтэй байна

$$X_3 = f^{\frac{1}{2}} \frac{\partial}{\partial x} - \frac{f_x}{2f^{\frac{1}{2}}} u \frac{\partial}{\partial u}.$$

iv) дурын $f(x)$ болон $g(x) = \frac{f_x}{2}$ функцүүдийн хувьд (3.19) систем нь X_0, X_1-с гадна дараах

$$
\begin{aligned}
X_4 &= f^{\frac{1}{2}}\int f^{-\frac{1}{2}}dx\frac{\partial}{\partial x} + \frac{t}{\alpha}\frac{\partial}{\partial t} - \frac{f_x}{2f^{\frac{1}{2}}}\int f^{-\frac{1}{2}}dxu\frac{\partial}{\partial u},\\
X_5 &= f^{\frac{1}{2}}\frac{\partial}{\partial x} - \frac{f_x}{2f^{\frac{1}{2}}}u\frac{\partial}{\partial u},\\
X_6 &= f^{-\frac{1}{2}}v\frac{\partial}{\partial u} + f^{\frac{1}{2}}u\frac{\partial}{\partial v}.
\end{aligned}
$$

3.2.2 Ли-гийн симметрүүдээр үүсгэгдсэн Ли алгебрийн дэд алгебруудын оптимал систем

Дифференциал тэгшитгэлийн бүлгэн анализийг хийхийн тулд төгсгөлөг хэмжээст Ли алгебрийн дэд алгебруудыг олох нь чухал байдаг. [24] ажилд дурдсан автоморфизмийн бүлгээр ижил хэмжээст дэд алгебрууд нь бие биендээ буух учир бие биендээ буудаггүй ялгаатай дэд алгебр болгоноос нэг нэг симметрийг төлөөлөгч болгон сонгон авч үүсгэсэн системийг оптимал систем гэж нэрлэнэ. 6 хүртэлх хэмжээстэй Ли алгебрийн оптимал системийг [48] ажилд олсон байдаг бөгөөд бидний судлах систем маань аль ч тохиолдолд 6-аас бага хэмжээст Ли алгебртэй симметрүүдтэй учир симметрүүдийн Ли алгебруудын оптимал системд харгалзах симметрийн инвариант шийдүүдийг олоход хангалттай юм.

Бид (3.19) системийн бүлгэн ангиллыг хийсэн учир одоо инфинитезимал симметрүүдийн Ли алгебрийн нэг хэмжээст оптимал систем болон бүлгэн инвариант шийдүүдийг олъё. Үүнээс хойшхи судалгаанд бид X_0 симметрийг тооцохгүй.

Тохиолдол ii)

Энэ тохиолдолд (3.19) систем

$$
\begin{cases}
\frac{\partial^\alpha u}{\partial t^\alpha} = v_x,\\
\frac{\partial^\alpha v}{\partial t^\alpha} = f(x)u_x + \left(\frac{\lambda_2 f(x)^{\frac{1}{2}}}{\lambda_1 + \int f(x)^{-\frac{1}{2}}dx} + \frac{f(x)_x}{2}\right)u,
\end{cases}
\tag{3.35}
$$

болно. Энд $f(x)$ хангалттай удаа дифференциалчлагдах функц, $\lambda_1, \lambda_2 \in \mathbb{R},\ \lambda_2 \neq 0$ байна. харгалзах инфинитезимал симметрүүд нь

$$\begin{aligned} X_1 &= u\frac{\partial}{\partial u} + v\frac{\partial}{\partial v}, \\ X_2 &= f^{\frac{1}{2}}\left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}}dx\right)\frac{\partial}{\partial x} + \frac{t}{\alpha}\frac{\partial}{\partial t} - \frac{f_x}{2f^{\frac{1}{2}}}\left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}}dx\right)u\frac{\partial}{\partial u} \end{aligned}$$

байна. X_1, X_2 нь Абелийн Ли алгебр үүсгэх ба оптимал систем нь

$$U_1 = X_1, \quad U_2 = X_2 + aX_1, \quad \text{энд } a \in \mathbb{R}$$

болно. U_2-д харгалзах характеристик тэгшитгэл нь

$$\frac{dx}{f^{\frac{1}{2}}\left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}}dx\right)} = \frac{\alpha dt}{t} = \frac{du}{\left[a - \frac{f_x}{2f^{\frac{1}{2}}}\left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}}dx\right)\right]u} = \frac{dv}{av} \quad (3.36)$$

болох ба эндээс I интегралууд нь $z = \left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}}dx\right)^{-\frac{1}{\alpha}} t$ ба

$$\begin{cases} u = f^{-\frac{1}{2}}\left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}}dx\right)^a \varphi(z), \\ v = \left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}}dx\right)^a \psi(z) \end{cases} \quad (3.37)$$

болно. (3.37)-ийг (3.35)-д орлуулснаар бид хувьсагчдын тоог бууруулж

$$\begin{cases} \frac{d^\alpha \varphi}{dz^\alpha} = a\psi - \frac{1}{\alpha}z\psi_z, \\ \frac{d^\alpha \psi}{dz^\alpha} = (a+\lambda_2)\varphi - \frac{1}{\alpha}z\varphi_z. \end{cases} \quad (3.38)$$

ердийн дифференциал тэгшитгэлийн систем гаргаж авна. U_1 симметр дараагийн тооцоонд ч мөн гарах бөгөөд ямар ч инвариант шийд өгөхгүй.

Тохиолдол iii)

Энэ тохиолдолд (3.19) систем

$$\begin{cases} \frac{\partial^\alpha u}{\partial t^\alpha} = v_x, \\ \frac{\partial^\alpha v}{\partial t^\alpha} = f(x)u_x + \left(\lambda_2 f^{\frac{1}{2}} + \frac{f_x}{2}\right)u, \end{cases} \quad (3.39)$$

болно. Энд $f(x)$ хангалттай удаа дифференциалчлагддаг функц ба $\lambda_2 \in \mathbb{R},\ \lambda_2 \neq 0$ байна. харгалзах инфинитезимал симметрүүд

$$X_1 = u\frac{\partial}{\partial u} + v\frac{\partial}{\partial v}, \quad X_3 = f^{\frac{1}{2}}\frac{\partial}{\partial x} - \frac{f_x}{2f^{\frac{1}{2}}}u\frac{\partial}{\partial u}$$

болох ба коммутатор нь 0 учир өмнөх тохиолдолтой адилаар Абелийн бүлэг болно. Оптимал систем нь

$$U_1 = X_1, \quad U_3 = X_3 + aX_1, \quad \text{where } a \in \mathbb{R}$$

болно. U_3 симметрийн хувьд характеристик арга хэрэглэснээр

$$\begin{cases} u = f^{-\frac{1}{2}} \exp\left(a \int f^{-\frac{1}{2}} dx\right) \varphi(t), \\ v = \exp\left(a \int f^{-\frac{1}{2}} dx\right) \psi(t), \end{cases} \tag{3.40}$$

инвариант шийдтэй болох ба хялбарчлагдсан систем нь

$$\begin{cases} \frac{d^\alpha \varphi(t)}{dt^\alpha} = a\psi(t), \\ \frac{d^\alpha \psi(t)}{dt^\alpha} = (a + \lambda_2)\varphi(t) \end{cases} \tag{3.41}$$

болно.

Тохиолдол iv)

Энэ тохиолдолд (3.19) систем нь

$$\begin{cases} \frac{\partial^\alpha u}{\partial t^\alpha} = v_x, \\ \frac{\partial^\alpha v}{\partial t^\alpha} = f(x)u_x + \frac{f_x}{2}u, \end{cases} \tag{3.42}$$

болно. Энд $f(x)$ хангалттай удаа тасралтгүй дифференциалчлагдах функц байна. Тооцоог хялбарчлахын тулд бид

$$\begin{aligned} Y_1 = \quad -X_4 \quad &= -f^{\frac{1}{2}} \int f^{-\frac{1}{2}} dx \frac{\partial}{\partial x} - \frac{t}{\alpha}\frac{\partial}{\partial t} + \frac{f_x}{2f^{\frac{1}{2}}} \int f^{-\frac{1}{2}} dx u \frac{\partial}{\partial u}, \\ Y_2 = \quad -X_5 \quad &= -f^{\frac{1}{2}}\frac{\partial}{\partial x} + \frac{f_x}{2f^{\frac{1}{2}}}u\frac{\partial}{\partial u}, \\ Y_3 = \quad X_1 \quad &= u\frac{\partial}{\partial u} + v\frac{\partial}{\partial v}, \\ Y_4 = \quad X_6 \quad &= f^{-\frac{1}{2}}v\frac{\partial}{\partial u} + f^{\frac{1}{2}}u\frac{\partial}{\partial v}. \end{aligned}$$

$[Y_i,Y_j]$	Y_1	Y_2	Y_3	Y_4
Y_1	0	Y_2	0	0
Y_2	$-Y_2$	0	0	0
Y_3	0	0	0	0
Y_4	0	0	0	0

Хүснэгт 3.1: Y_1, Y_2, Y_3, Y_4-ийн коммутатор хүснэгт.

суурь сонгож авъя. Дээрх суурийн хувьд коммутаторыг Хүснэгт 3.1-д харуулав (энд, i, j-ээр харгалзан мөр ба баганыг дугаарлав).

Хүснэгт 3.1-ээс Ли алгебр нь [48]-ийн $A_2 \oplus 2A_1$ алгебртэй адил болох нь харагдана. Тиймээс Y_1, Y_2, Y_3, Y_4-р үүсгэгдсэн Ли алгебрийн оптимал систем нь дараах байдлаар өгөгдөнө.

$$\begin{aligned}
U_1 &= Y_3 = X_1, \\
U_4 &= Y_1 - a_1Y_3 - a_2Y_4 = -a_1X_1 - X_4 - a_2X_6, \text{ энд } a_1, a_2 \in \mathbb{R}, \\
U_5 &= Y_2 - a_1Y_3 - a_2Y_4 = -a_1X_1 - X_5 - a_2X_6, \\
&\quad \text{энд } (a_1, a_2) \in \{(\pm 1, a), (0, \pm 1), (0, 0) | a \in \mathbb{R}\}, \\
U_6 &= a_1Y_3 + Y_4 = a_1X_1 + X_6, \text{ энд } a_1 \in \mathbb{R}.
\end{aligned}$$

U_4-ийн хувьд инвариант гадаргуугийн нөхцөл

$$\begin{cases} f^{\frac{1}{2}} \left(\int f^{-\frac{1}{2}}dx\right) u_x + \frac{t}{\alpha}u_t = \left(a_1 - \frac{f_x}{2f^{\frac{1}{2}}} \int f^{-\frac{1}{2}}dx\right) u + a_2 f^{-\frac{1}{2}} v \\ f^{\frac{1}{2}} \left(\int f^{-\frac{1}{2}}dx\right) v_x + \frac{t}{\alpha}v_t = a_1 v + a_2 f^{\frac{1}{2}} u, \end{cases} \tag{3.43}$$

болох бөгөөд эндээс $z = t\left(\int f^{-\frac{1}{2}}dx\right)^{-\frac{1}{\alpha}}$. Анзац буюу хувиргалт нь

$$\begin{cases} u = f^{-\frac{1}{2}} \left(\int f^{-\frac{1}{2}}dx\right)^{a_1+a_2} \varphi(z) + f^{-\frac{1}{2}} \left(\int f^{-\frac{1}{2}}dx\right)^{a_1-a_2} \psi(z) \\ v = \left(\int f^{-\frac{1}{2}}dx\right)^{a_1+a_2} \varphi(z) - \left(\int f^{-\frac{1}{2}}dx\right)^{a_1-a_2} \psi(z) \end{cases} \tag{3.44}$$

байна. (3.44)-ийг (3.42)-д орлуулснаар

$$\begin{cases} \frac{d^\alpha \varphi}{dz^\alpha} = (a_2 + a_1)\varphi - \frac{1}{\alpha} z\varphi_z \\ \frac{d^\alpha \psi}{dz^\alpha} = (a_2 - a_1)\psi + \frac{1}{\alpha} z\psi_z \end{cases} \tag{3.45}$$

хялбарчлагдсан систем гарна. Төсөөтэйгээр, U_5-д харгалзах хувиргалт

$$\begin{cases} u = f^{-\frac{1}{2}} \exp\left[(a_1+a_2)\int f^{-\frac{1}{2}}dx\right]\varphi(t) + f^{-\frac{1}{2}} \exp\left[(a_1-a_2)\int f^{-\frac{1}{2}}dx\right]\psi(t) \\ v = \exp\left[(a_1+a_2)\int f^{-\frac{1}{2}}dx\right]\varphi(t) - \exp\left[(a_1-a_2)\int f^{-\frac{1}{2}}dx\right]\psi(t). \end{cases} \tag{3.46}$$

болох ба хялбарчлагдсан систем нь

$$\begin{cases} \frac{d^\alpha \varphi(t)}{dt^\alpha} = (a_2+a_1)\varphi(t), \\ \frac{d^\alpha \psi(t)}{dt^\alpha} = (a_2-a_1)\psi(t). \end{cases} \tag{3.47}$$

болно. U_6-д харгалзах инвариант шийд байхгүй.

3.2.3 Бүлгэн инвариант шийдүүд

Өмнөх хэсэгт олсон хялбаршуулсан тэгшитгэлүүдийн шийдийг олох замаар (3.19) системийн инвариант шийдийг олно. (3.38)-с (3.41)-д өгөгдсөн хялбаршуулсан системүүд нь

$$\begin{cases} \dfrac{d^\alpha \varphi}{dz^\alpha} = a_1\psi + \dfrac{b_1}{\alpha} z\psi', \\ \dfrac{d^\alpha \psi}{dz^\alpha} = a_2\varphi + \dfrac{b_2}{\alpha} z\varphi', \end{cases} \tag{3.48}$$

гэсэн ерөнхий хэлбэртэй байгааг харж болно. Энд, a_1, a_2, b_1, b_2 нь тогтмол тоонууд байна. $g(x) = \frac{f(x)_x}{2}$ үед (3.45), (3.47) системүүд нь

$$\frac{d^\alpha \varphi}{dz^\alpha} = a\varphi + \frac{b}{\alpha} z\varphi', \tag{3.49}$$

ерөнхий хэлбэртэй байна. Энд, a, b нь тогтмол тоонууд байна. Өөрөөр хэлбэл, (3.19)-ийн инвариант шийдийг олох бодлого нь үндсэндээ (3.48) болон (3.49) тэгшитгэлийн шийдийг олох бодлого руу шилжлээ гэсэн үг юм. (3.48), (3.49)-ийн шийдийн тухай бид [39] ажилдаа дэлгэрэнгүй дурьдсан бөгөөд [38] ажлын Лемма 2.1, 2.2-оос бид дараах үр дүнг шууд гаргаж авч болно.

Энд Миттаг-Леффлер болон өргөтгөсөн Райт функцээр илэрхийлэгдсэн шийдүүд нь $z \in \mathbb{R}$ мужид тодорхойлогдсон байгаа бол Фокс-Эйч функцээр илэрхийлэгдсэн шийдүүд нь $z > 0$ мужид тодорхойлогдсон байгааг дурдъя.

Тохиолдол i)

Энэ тохиолдолд, (3.35)-ийн шийдүүд дараах байдлаар илэрхийлэгдэнэ:

1. $0 < \alpha < 1$ үед [39]-ийн Лемма 2.1-ийг ашиглавал (3.38)-д $a_1 = a$, $a_2 = a + \lambda_2$ ба $b_1 = b_2 = 1$ гэж авбал бид

$$\begin{aligned} u(x,t) &= cf^{-\frac{1}{2}}(x)\left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}}dx\right)^a \varphi\left(\left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}}dx\right)^{-1/\alpha} t\right), \\ v(x,t) &= c\left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}}dx\right)^a \psi\left(\left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}}dx\right)^{-1/\alpha} t\right) \end{aligned} \tag{3.50}$$

өгөгдсөн инвариант шийдтэй болно. Энд,

$$\begin{aligned} \varphi(z) &= H^{2,0}_{1,2}\left[\frac{z^{-2\alpha}}{4}\middle| \begin{array}{c} (1, 2\alpha) \\ \left(\frac{a}{2}+\frac{1}{2}, 1\right), \left(\frac{a+\lambda_2}{2}, 1\right) \end{array}\right], \\ \psi(z) &= H^{2,0}_{1,2}\left[\frac{z^{-2\alpha}}{4}\middle| \begin{array}{c} (1, 2\alpha) \\ \left(\frac{a}{2}, 1\right), \left(\frac{a+\lambda_2}{2}+\frac{1}{2}, 1\right) \end{array}\right]. \end{aligned}$$

2. $\alpha \geq 1$ үед Лемма 2.1 [39]-ийн гуравдугаар хэсгийг ашиглавал бид

$$u(x,t) = cf^{-\frac{1}{2}}(x)\left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}}dx\right)^a \varphi\left(\left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}}dx\right)^{-1/\alpha} t\right), \tag{3.51}$$

$$v(x,t) = c\left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}}dx\right)^a \psi\left(\left(\lambda_1 + \int f^{-\frac{1}{2}}dx\right)^{-1/\alpha} t\right) \tag{3.52}$$

гэж өгөгдсөн инвариант шийдтэй болно. Энд,

$$\begin{aligned} \varphi(z) &= \sum_{k=1}^{n} c_{k,1} z^{\alpha-k} {}_3\Psi_1\left[4z^{2\alpha}\middle| \begin{array}{c} \left(\frac{a}{2}-\frac{k}{2\alpha}+1, 1\right), \left(\frac{a+\lambda_2}{2}-\frac{k}{2\alpha}+\frac{1}{2}, 1\right), (1,1) \\ (1+\alpha-k, 2\alpha) \end{array}\right] \\ &+ 2\sum_{k=1}^{n} c_{k,2} z^{2\alpha-k} {}_3\Psi_1\left[4z^{2\alpha}\middle| \begin{array}{c} \left(\frac{a}{2}-\frac{k}{2\alpha}+\frac{3}{2}, 1\right), \left(\frac{a+\lambda_2}{2}-\frac{k}{2\alpha}+1, 1\right), (1,1) \\ (1+2\alpha-k, 2\alpha) \end{array}\right], \\ \psi(z) &= 2\sum_{k=1}^{n} c_{k,1} z^{2\alpha-k} {}_3\Psi_1\left[4z^{2\alpha}\middle| \begin{array}{c} \left(\frac{a}{2}-\frac{k}{2\alpha}+1, 1\right), \left(\frac{a+\lambda_2}{2}-\frac{k}{2\alpha}+\frac{3}{2}, 1\right), (1,1) \\ (1+2\alpha-k, 2\alpha) \end{array}\right] \\ &+ \sum_{k=1}^{n} c_{k,2} z^{\alpha-k} {}_3\Psi_1\left[4z^{2\alpha}\middle| \begin{array}{c} \left(\frac{a}{2}-\frac{k}{2\alpha}+\frac{1}{2}, 1\right), \left(\frac{a+\lambda_2}{2}-\frac{k}{2\alpha}+1, 1\right), (1,1) \\ (1+\alpha-k, 2\alpha) \end{array}\right] \end{aligned}$$

ба $n \in \mathbb{N}:\ 0 \leq n-1 < \alpha \leq n$, c, $c_{k,1}$, $c_{k,2}$ $(k = 1, \ldots, n)$ нь тогтмол тоонууд байна.

3.2.4 Тохиолдол ii)

Энэ тохиолдолд Лемма 2.2 [39]-ийг $a_1 = a$ and $a_2 = a + \lambda_2$ ашигласнаар (3.39)-ийн шийд

$$\begin{aligned} u(x,t) &= f^{-\frac{1}{2}} \exp\left(a \int f^{-\frac{1}{2}} dx\right) \varphi(t), \\ v(x,t) &= \exp\left(a \int f^{-\frac{1}{2}} dx\right) \varphi(t), \end{aligned} \tag{3.53}$$

гэж олдоно. Энд

$$\begin{aligned} \varphi(t) &= \sum_{k=1}^{n} c_{k,1} t^{\alpha-k} E_{2\alpha,1+\alpha-k}\left(a(a+\lambda_2)t^{2\alpha}\right) + a \sum_{k=1}^{n} c_{k,2} t^{2\alpha-k} E_{2\alpha,1+2\alpha-k}\left(a(a+\lambda_2)t^{2\alpha}\right), \\ \psi(t) &= (a+\lambda_2) \sum_{k=1}^{n} c_{k,1} t^{2\alpha-k} E_{2\alpha,1+2\alpha-k}\left(a(a+\lambda_2)t^{2\alpha}\right) + \sum_{k=1}^{n} c_{k,2} t^{\alpha-k} E_{2\alpha,1+\alpha-k}\left(a(a+\lambda_2)t^{2\alpha}\right); \end{aligned}$$

ба $n \in \mathbb{N}: \ 0 \leq n-1 < \alpha \leq n,$, $c_{k,1}$, $c_{k,2}$ $(k = 1, \ldots, n)$ нь тогтмол тоонууд байна.

$g(x) = 0$ тохиолдолд зөвхөн $f(x) = x^2$ үед л (3.19) тэгшитгэл хувьсагч нь ялгагдах тэгшитгэлд шилждэг ([38]) бол дээрх тохиолдолд дурын $f(x)$ функцийн хувьд хувьсагч нь ялгагдах тэгшитгэлд шилждэг юм. Тухайлбал, бид жишээ болгон (3.19) тэгшитгэлийн шийдийг $f(x) = x^6$, $g(x) = 3x^5 + x^3$ үед (3.53)-ээр өгөгдсөн $u(x)$ шийдийг $c_{1,2} = 0$, $c_{1,1} = 1$ үед Зураг 2.1-д дүрсэлж үзүүлэв.

3.2.5 Тохиолдол iv)

f, g-ийн өмнөх тохиолдлуудаас ялгаатай нь дурын $f(x)$ ба $g(x) = \frac{f_x}{2}$ байх тохиолдолд инвариант шийдүүд нь бутархай эрэмбийн хоёр ердийн дифференциал тэгшитгэлүүдийн шийдүүдийн нийлбэр хэлбэрээр илэрхийлэгдэнэ. U_4-д харгалзах (3.42)-ийн инвариант шийдүүд нь дараах байдлаар иоэрхийлэгдэнэ:

1. $0 < \alpha < 1$ үед [39] ажлын Лемма 2.2 $a = a_2 - a_1$, $b = 1$ үед ашиглавал



(a) The case $\alpha = \frac{1}{4}$



(b) The case $\alpha = \frac{7}{8}$

Зураг 3.1: $f(x) = x^2,\ g(x) = 3x^5 + x^3$ үеийн (3.19) тэгшитгэлийн шийд (3.53)

инвариант шийд

$$
\begin{aligned}
u(x,t) &= cf^{-\frac{1}{2}}t^{(a_1-a_2)\alpha}\Psi\left(-\frac{\int f^{-\frac{1}{2}}dx}{t^{\alpha}};-\alpha,1+(a_1-a_2)\alpha\right),\\
v(x,t) &= -ct^{(a_1-a_2)\alpha}\Psi\left(-\frac{\int f^{-\frac{1}{2}}dx}{t^{\alpha}};-\alpha,1+(a_1-a_2)\alpha\right) \quad (3.54)
\end{aligned}
$$

болно.

2. $\alpha \geq 1$ үед (3.45)-ийн эхний тэгшитгэлд $a = a_1 + a_2$, $b = -1$ ба хоёр дахь тэгшитгэлд $a = a_2 - a_1$, $b = 1$ гэж [39] ажлын Лемма 2.2

ашиглавал U_4-д харгалзах инвариант шийдүүд нь

$$u(x,t) = f^{-\frac{1}{2}}\left(\int f^{-\frac{1}{2}}dx\right)^{a_1+a_2-1} t^{\alpha}\sum_{k=1}^{n} c_{k,1}\frac{\left(\int f^{-\frac{1}{2}}dx\right)^{\frac{k}{\alpha}}}{t^k}\varphi_k\left(\frac{t}{\left(\int f^{-\frac{1}{2}}dx\right)^{\frac{1}{\alpha}}}\right) \quad (3.55)$$

$$+f^{-\frac{1}{2}}\left(\int f^{-\frac{1}{2}}dx\right)^{a_1-a_2-1} t^{\alpha}\sum_{k=1}^{n} c_{k,2}\frac{\left(\int f^{-\frac{1}{2}}dx\right)^{\frac{k}{\alpha}}}{t^k}\psi_k\left(\frac{t}{\left(\int f^{-\frac{1}{2}}dx\right)^{\frac{1}{\alpha}}}\right),$$

$$v(x,t) = \left(\int f^{-\frac{1}{2}}dx\right)^{a_1+a_2-1} t^{\alpha}\sum_{k=1}^{n} c_{k,1}\frac{\left(\int f^{-\frac{1}{2}}dx\right)^{\frac{k}{\alpha}}}{t^k}\varphi_k\left(\frac{t}{\left(\int f^{-\frac{1}{2}}dx\right)^{\frac{1}{\alpha}}}\right) \quad (3.56)$$

$$-\left(\int f^{-\frac{1}{2}}dx\right)^{a_1-a_2-1} t^{\alpha}\sum_{k=1}^{n} c_{k,2}\frac{\left(\int f^{-\frac{1}{2}}dx\right)^{\frac{k}{\alpha}}}{t^k}\psi_k\left(\frac{t}{\left(\int f^{-\frac{1}{2}}dx\right)^{\frac{1}{\alpha}}}\right), \quad (3.57)$$

болно. Энд

$$\varphi_k(z) = {}_2\Psi_1\left[-z^{\alpha}\left|\begin{array}{c}\left(-a_1-a_2-\frac{k}{\alpha}+1,1\right),(1,1)\\(1+\alpha-k,\alpha)\end{array}\right.\right],$$

$$\psi_k(z) = {}_2\Psi_1\left[z^{\alpha}\left|\begin{array}{c}\left(-a_1+a_2-\frac{k}{\alpha}+1,1\right),(1,1)\\(1+\alpha-k,\alpha)\end{array}\right.\right].$$

байна.

[39] ажлын Лемма 2.2 ашиглавал U_5-д харгалзах инвариант шийд

$$u(x,t) = f^{-\frac{1}{2}}\exp\left((a_1+a_2)\int f^{-\frac{1}{2}}dx\right)t^{\alpha}\sum_{k=1}^{n} c_{k,1}t^{-k}\varphi_k(t)$$

$$+ \quad f^{-\frac{1}{2}}\exp\left((a_1-a_2)\int f^{-\frac{1}{2}}dx\right)t^{\alpha}\sum_{k=1}^{n} c_{k,2}t^{-k}\psi_k(t),$$

$$v(x,t) = \exp\left((a_1+a_2)\int f^{-\frac{1}{2}}dx\right)t^{\alpha}\sum_{k=1}^{n} c_{k,1}t^{-k}\varphi_k(t)$$

$$- \quad \exp\left((a_1-a_2)\int f^{-\frac{1}{2}}dx\right)t^{\alpha}\sum_{k=1}^{n} c_{k,2}t^{-k}\psi_k(t), \quad (3.58)$$

болно. Энд

$$\varphi_k(t) = E_{\alpha,1+\alpha-k}((a_1 + a_2)t^\alpha), \quad \psi_k(t) = E_{\alpha,1+\alpha-k}((a_2 - a_1)t^\alpha)$$

ба $(a_1, a_2) \in \{(\pm 1, a), (0, \pm 1), (0, 0) | a \in \mathbb{R}\}$ байна.

Номзүй

[1] S. Albeverio, F. Gesztesy, R. Hoegh-Krohn, H. Holden, *Solvable Models in Quantum Mechanics*, AMS Chelsea Publishing, (2004),

[2] H. Cornean, A. Michelangeli and K. Yajima, *Two dimensional Schrödinger operators with point interactions: Threshold expansions, zero modes and L^p-boundedness of wave operators.* Reviews in Mathematical Physics Vol. 31, No. 04, 1950012 (2019)

[3] M. Born and V. A. Fock, *Beweis des Adiabatensatzes*, Zeitschrift für Physik A. **51** (1928), 165-180.

[4] G. Dell'Antonio, A. Michelangeli, R. Scandone and K. Yajima, *The L^p-boundedness of wave operators for the three dimensional multi-centre point interaction*, Ann. Inst. H. Poincaré **19** (2018), 283–322.

[5] D. Dürr and P. Pickl, *On adiabatic pair creation*, Comm. Math. Phys. **282** (2008), 161–198.

[6] Frohlich, J. (1974). *Existence of dressed one-electron states in a class of persistent models.* Fortschr. Phys., 22: 159–198.

[7] Frohlich, J. and Pizzo, A. (2010). *Renormalized Electron Mass in Nonrelativistic QED.* Communications in Mathematical Physics, 294(2), 439–470.

[8] Galtbayar A., Jensen A., Yajima K., *The Nelson model with less than two photons.* Ann. Henri Poincare 4 (2003), no. 2, 239-273.

[9] Georgescu, V., Gérard, C., Møller, J. S., *Spectral theory of massless Pauli-Fierz models.* Comm. Math. Phys., 249 (2004), no. 1, 29–78.

[10] Griesemer, M., Lieb, E.H., Loss, M.: Ground states in non-relativistic quantum electrodynamics. Invent. Math. 145, 557–595 (2001)

[11] Hiroshima, F. and Spohn, H., *Mass renormalization in nonrelativistic QED.* J. Math. Phys. 46, (2005), 042302.

[12] T. Kato, *On the Adiabatic Theorem of Quantum Mechanics*, J. Phys. Soc. Japan **5** (1950), 435-439.

[13] R. A. Minlos, H. Spohn, *The three-body problem in radioactive decay: the case of one atom and at most two photons.* Topics in statistical and theoretical physics, 159–193. Amer. Math. Soc. Transl. Ser. 2, 177. Amer Math. Soc., Providence, RI, 1996.

[14] T. Miyao, *Polaron with at most one phonon in the weak coupling limit*, Monatsh. Math., 157 (2009), no. 4, 365-378.

[15] S. Teufel, *Adiabatic perturbataion theory in quantum dynamics*, LNM **1821**, Springer (2003).

[16] K. Yajima, *The surfboard Schrödinger equation*, Commun. Math. Phys. **96** (1984), 349-360.

[17] K. Yajima, *L^1 and L^∞-boundedness of wave operators for three dimensional Schrödinger operators with Threshold Singularities*, Tokyo J. Math., 41 (2018), 385-406.

[18] Ovsyannikov, L.V.: Group Analysis of Differential Equations. Academic Press, New York (1982)

[19] Bluman, G.W., Anco, S.C.: Symmetry and integration methods for differential equations. Applied Mathematical Sciences 154, Springer-Verlag, New York (2002)

[20] Bluman, G.W., Cheviakov, A.F., Anco, S.C.: Applications of symmetry methods to partial differential equations. Applied Mathematical Sciences, 168. Springer, New York (2010)

[21] Ibragimov, N.H.: Elementary Lie Group Analysis and Ordinary Differential Equations. John Wiley, Chichester (1999)

[22] Ibragimov, N.H.(Ed.): CRC Handbook of Lie Group Analysis of Differential Equations, Symmetries, Exact Solutions and Conservation Laws. vol. 1. CRC Press, Boca Raton, Florida (1994)

[23] Ibragimov, N.H.: A Practical Course in Differential Equations and Mathematical Modelling. Higher Education Press, World Scientific Publishing Co. Ptl. Ltd., Beijing (2010)

[24] Olver, P.J.: Applications of Lie Group to Differential Equations. Graduate texts in Mathematics, vol. 107, Springer-Verlag (2002)

[25] Hydon, P.E.: Symmetry methods for differential equations. A beginner's guide. Cambridge Texts in Applied Mathematics, Cambridge University Press (2000)

